

БАТЛАВ.  
БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ .....М.ИТГЭЛ



**“МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН ФИЛОСОФИ”**

Олон улсын эрдэм шинжилгээний хурлын удирдамж

2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр

**Үндэслэл**

Дэлхий дахины нийгэм, эдийн засгийн нөхцөл, цар тахал, уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдэл, биологийн төрөл зүйлийн усталт, технологийн хөгжил, бүтээмэл оюун ба цахим хуваагдал зэрэг нь ойрын ирээдүйг тодорхойгүй, таамаглахад бэрхтэй, тогтворгүй, ээдрээтэй болгож байна. Урьдчилан таамаглах боломжгүйгээр хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд ирээдүйн иргэдийг бэлтгэх, өнөө бидэнд тулгамдаж буй сорилтуудыг даван туулахад боловсролын салбарын үүрэг, хариуцлагыг шинээр харах шаардлагатай болов.

Одоо үүсээд буй хийгээд цаашид үргэлжлэх дээрх нөхцөл байдал, төлөв хандлагыг нэг талаас сорилт, нөгөө талаас боломж хэмээн харах, цаашлаад оновчтой шийдэл, хариу үйлдэл үзүүлэх нь нэн чухал болов. Дээрх төлөв байдал, төсөөлөлд үндэслэн олон улсын байгууллагууд, дэлхийн улс, орнууд ирээдүйн боловсрол, хүн хүчний бодлогын асуудлыг концепцийн шинжтэй баримт бичгүүддээ тусган хэрэгжүүлэхийг эрмэлзэх болжээ.

Түүнчлэн дээрх сорилт, нөхцөл байдлыг даван туулах, оновчтой хариу үйлдэл үзүүлэхэд боловсролын судалгаа, инновацыг хөгжүүлэхэд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байгааг судлаачид онцолж байна. Үндэсний боловсролын тогтолцоо нь түүх, соёл, нийгэм, улс төр, эдийн засгийн үр нөлөөнөөс бүрдсэн цогц ойлголт бөгөөд энэхүү тогтолцоог тогтвортой хөгжүүлэхэд чиглэсэн судалгаа-инновацыг тодорхой хэдэн чиглэлд хийвэл илүү үр дүнд хүрэх боломжтой гэж үзэж байгаагийн тэргүүнд боловсролын философи болон соёлын чиглэлд хийх инновац нэрлэгдэж байна.

Иймд Боловсролын Судалгааны Үндэсний Хүрээлэн хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд ирээдүйн монгол иргэдийг бэлтгэхэд боловсролын хүлээх үүрэг, хариуцлага, үзүүлэх хариу үйлдлийг боловсролын философи, парадигм, онолын байр сууринаас тодорхойлох, оновчтой шийдэл, санаачилгыг үндэсний болон олон улсын түвшинд шат дараатайгаар хэлэлцэх арга хэмжээ авч байна. Энэ зорилгоор дотоод, гадаадын их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын багш, судлаачдын мэдлэг, туршлага, мэдээллийг үндэсний болоод бүс нутаг, олон улсын хэмжээнд солилцох, түгээх, цаашид хамтарсан судалгааны төсөл, хөтөлбөр боловсруулах санаачилга, боломжийг эрчимжүүлэх зорилгоор **“Монголын боловсролын хөгжлийн философи”** олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2024 оны 11 дүгээр сарын 28-нд зохион байгуулах гэж байна.

**Оролцогчдын хамрах хүрээ**

Дотоод, гадаадын их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, мэргэжлийн холбоод, хувь судлаачид оролцох боломжтой.

## **Илтгэлд тавих ерөнхий шаардлага**

*Илтгэл нь сэдэв, агуулгын хувьд дараах хүрээг хамарсан байна:*

- Боловсрол, сургалтын хөгжлийн төлөв хандлагыг урьдчилан таамаглах, хариу үйлдэл үзүүлэх философи үзэл санаа;
- Монголын боловсролын зорилгыг тодорхойлох философи үндэслэл;
- Ирээдүйн нийгмийн төлөв хандлагад дасан зохицох XXI зууны монгол хүний дүр төрх, шинж, чадамжийг тодорхойлох философи үндэслэл;
- Өнөөгийн монгол суралцагчийг ирээдүйд ямар иргэн болгож хөгжүүлж, төлөвшүүлэх үзэл санааны философи үндэслэл;
- Сургалтын тогтолцоог бүхэлд нь эсвэл тодорхой бүрэлдэхүүн (*агуулга, аргазүй, хүний нөөц, орчин, үнэлгээ, удирдлага, менежмент*) хэсгийг хөгжүүлэх философи үзэл санаа;
- Одоогийн сургалтыг сайжруулах, хөгжүүлэх бодлого, шийдлийн философи үндэслэл;

## **Илтгэлд тавих техникийн шаардлага**

- Илтгэлийн PPT бэлдсэн байх;
- Илтгэлийн эхэнд илтгэлийн нэр /сэдэв/, зохиогчийн овог, нэр, эрдмийн зэрэг, цол, эрхэлж буй ажил, цахим хаягийг бичих;
- Илтгэлийн нэрийг монгол, англи хэлээр бичсэн байх;
- Илтгэлийн бүтэц: 5-8 түлхүүр үг, 250-400 үгэнд багтаан монгол, англи хэлээр бичсэн хураангуй, оршил, үндсэн агуулга, дүгнэлт, эшлэл авсан ном зүй, зураг, график, хүснэгтийг хавсаргах;
- Илтгэлийг Microsoft Word программ ашиглан бичих;
- Үсгийн фонт: Times New Roman, үсгийн хэмжээ: 11, мөр хоорондын зай: 1.15, догол мөр: 0.5 см байх;
- Илтгэлийн хэмжээ: А4 цаасны хэмжээтэй 5-10 хуудаст багтаах;

## **Илтгэл илгээх заавар**

Илтгэлийн эхийг [энд](#) өгсөн загварын дагуу бэлтгэн илгээнэ. Хурлын илтгэлийг бүрэн эхээр 2024 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийг дуустал [khaliun@mier.mn](mailto:khaliun@mier.mn) болон [bayanzul@mier.mn](mailto:bayanzul@mier.mn) хаягаар хүлээн авна. Шаардлага хангасан илтгэлүүдийг эмхэтгэл болгон хэвлэнэ.

### **Зохион байгуулах ажлын хэсэгтэй холбоо барих мэдээлэл:**

*Ажлын хэсгийн ахлагч:*

БСҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга С.Санжаабадам,  
мэйл хаяг: [sanjaabadam@mier.mn](mailto:sanjaabadam@mier.mn)

*Нарийн бичгийн дарга:*

БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Халиун,  
мэйл хаяг: [khaliun@mier.mn](mailto:khaliun@mier.mn), холбогдох утас: 99550090  
БСҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Баянзул,  
мэйл хаяг: [bayanzul@mier.mn](mailto:bayanzul@mier.mn), холбогдох утас: 94095644